



НЭЭЛТТЭЙ
НИЙГЭМ
ФОРУМ

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ГАДААД ЗЭЭЛИЙН МЭДЭЭЛЭЛ, ТӨСЛҮҮДИЙН САНХҮҮГИЙН ИЛ ТОД БАЙДАЛ





НЭЭЛТТЭЙ
НИЙГЭМ
ФОРУМ

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ГАДААД ЗЭЭЛИЙН МЭДЭЭЛЭЛ, ТӨСЛҮҮДИЙН САНХҮҮГИЙН ИЛ ТОД БАЙДАЛ

СУДАЛГААНЫ ТАЙЛАН

УЛААНБААТАР
2023 ОН

ННА 65
ДАА 330
Б-341

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ГАДААД ЗЭЭЛИЙН МЭДЭЭЛЭЛ, ТӨСЛҮҮДИЙН САНХҮҮГИЙН ИЛ ТОД БАЙДАЛ

Судалгааны тайлан

Судалгаа хийсэн: С.Баттулга ахлагчтай “Монголын эдийн засгийн
шинжилгээ, судалгааны төв” ТББ-ын баг

*Энэхүү судалгааны үр дүн, санал зөвлөмж нь уг судалгааг гүйцэтгэсэн
багийн үзэл бодол, байр суурь бөгөөд Нээлттэй Нийгэм Форумын
албан ёсны байр суурийг төлөөлөхгүй.*

© Нээлттэй Нийгэм Форум, 2023 он

Уг тайланг ашиглахдаа эх сурвалжийг дурдана уу.

Хаяг: Монгол Улс,
Улаанбаатар хот-14240,
Сүхбаатар дүүрэг,
Жамьян гүний гудамж-5/1

Утас: 976-76113207

Факс: 976-11-324857

Веб: <http://www.forum.mn>

И-мэйл: osf@forum.mn

ISBN: 978-9919-9926-9-9

Эхийг “Би Си Ай” ХХК-д бэлтгэж, хэвлэв.

АГУУЛГА

ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ	5
ГРАФИКИЙН ЖАГСААЛТ	5
ДҮРСЛЭЛИЙН ЖАГСААЛТ	6
ТОВЧИЛСОН ҮГСИЙН ЖАГСААЛТ	6
ХУРААНГУЙ	9
1. УДИРТГАЛ	13
2. ЗАСГИЙН ГАЗРЫН ГАДААД ЗЭЭЛ, ТҮҮНИЙ БҮТЭЦ (2000-2021 ОН)	15
3. ЗАСГИЙН ГАЗРЫН ГАДААД ЗЭЭЛЭЭР ХЭРЭГЖИЖ БҮЙ ТӨСЛҮҮД, ТЭДГЭЭРИЙН ҮР ДҮНТЭЙ БАЙДАЛ	18
4. ЗАСГИЙН ГАЗРЫН ГАДААД ЗЭЭЛЭЭР ХЭРЭГЖИЖ БҮЙ ТӨСЛҮҮДИЙН САНХҮҮГИЙН ИЛ ТОД БАЙДАЛ	25
Шилэн дансны цахим системд мэдээлэл нийтэлсэн байдал	25
Монгол Улсын Засгийн газрын гадаад зээл, тусламжийн удирдлагын мэдээллийн системд мэдээлэл нийтэлсэн байдал	30
5. БУСАД УЛС ОРНЫ ЗАСГИЙН ГАЗРЫН ГАДААД ЗЭЭЛИЙН МЭДЭЭЛЭЛ БОЛОН ТӨСЛҮҮДИЙН САНХҮҮГИЙН ИЛ ТОД БАЙДЛЫГ ХАНГАЖ БҮЙ САЙН ТУРШЛАГА	34
6. ДҮГНЭЛТ	37
7. САНАЛ, ЗӨВЛӨМЖ	39
ХАВСРАЛТ	41
Хавсралт 1	42
А. Төслүүд төсөв/гүйцэтгэлийн мэдээллээ нийтэлсэн байдал, 2021 он	42
Б. Төслүүд хөрөнгө оруулалт, тендер, худалдан авалтын мэдээллээ нийтэлсэн байдал, 2021 он	55

В. Төслүүд шилэн дансны бусад мэдээллээ нийтэлсэн байдал, 2021 он	64
Хавсралт 2.....	74
А1. Төсөв/гүйцэтгэлийн мэдээллээ хамгийн сайн нийтэлсэн төслүүд, 2021 он.....	74
А2. Төсөв/гүйцэтгэлийн мэдээллээ нийтлээгүй төслүүд, 2021 он	74
Б1. Хөрөнгө оруулалт, тендер, худалдан авалтын мэдээллээ бүрэн нийтэлсэн төслүүд, 2021 он.....	76
Б2. Хөрөнгө оруулалт, тендер, худалдан авалтын мэдээлэл нийтлээгүй төслүүд, 2021 он.....	77
Хавсралт 3.....	80
А. Гадаад улс, олон улсын байгууллагын зээл, тусламжийн хөрөнгөөр хэрэгжиж буй төсөл, арга хэмжээнүүд Удирдлагын мэдээллийн системд төсөл, арга хэмжээний үр дүнгийн мэдээллээ нийтэлсэн байдал.....	80
Б. Гадаад улс, олон улсын байгууллагын зээл, тусламжийн хөрөнгөөр хэрэгжиж буй төсөл, арга хэмжээнүүд Удирдлагын мэдээллийн системд төсөв, санхүүгийн мэдээллээ нийтэлсэн байдал.....	87
Хавсралт 4.....	94
ODAMIS системд мэдээллээ хамгийн сайн нийтэлсэн төслүүд, 2021 он	94
НОМ ЗҮЙ	95

ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

Хүснэгт 1.	Монгол Улсын нийт гадаад өр, Засгийн газрын гадаад өрийн үлдэгдэл (сая ам. доллар).....	15
Хүснэгт 2.	Монгол Улсын нийт гадаад өрийн үлдэгдэл, улсаар (дүнд эзлэх хувь).....	17

ГРАФИКИЙН ЖАГСААЛТ

График 1.	Засгийн газрын гадаад өрийн үлдэгдэл, 2011-2021 он (тэрбум ам. доллар)	16
График 2.	Засгийн газрын авсан гадаад зээл (сая ам. доллар)	18
График 3.	Засгийн газрын гадаад зээлийн ашиглалт, салбараар, 2018-2020 он.....	19
График 4.	Монгол Улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөрийн нийт санхүүжилтийн дүнд гадаадын зээл, тусламжийн эзлэх хувь	20
График 5.	Төсвийн алдагдлыг санхүүжүүлэх зориулалтаар авсан гадаад зээлийн үлдэгдэл (тэрбум төгрөг)	22
График 6.	Гадаад улс, олон улсын байгууллагын зээл, тусламжийн хөрөнгөөр хэрэгжиж буй төсөл, арга хэмжээнүүд үр дүнгийн мэдээллээ нийтэлсэн байдал.....	23
График 7.	Төслүүд төсөв / гүйцэтгэлийн мэдээллээ нийтэлсэн байдал, 2021 он.....	26
График 8.	Төслүүд хөрөнгө оруулалт, тендер, худалдан авалтын мэдээллээ нийтэлсэн байдал, 2021 он	28
График 9.	Төслүүд шилэн дансны бусад мэдээллээ нийтэлсэн байдал, 2021 он.....	29
График 10.	Гадаад улс, олон улсын байгууллагын зээл, тусламжийн хөрөнгөөр хэрэгжиж буй төсөл, арга хэмжээнүүд төсөв, санхүүгийн мэдээллээ нийтэлсэн байдал.....	33

ДҮРСЛЭЛИЙН ЖАГСААЛТ

Дүрслэл 1.	www.odamis.mof.gov.mn цахим хуудасны эхлэл.....	31
Дүрслэл 2.	www.odamis.mof.gov.mn цахим хуудсанд тухайн төслийн мэдээллийг байршуулсан байдал.....	31

ТОВЧИЛСОН ҮГСИЙН ЖАГСААЛТ

ААН	Аж ахуйн нэгж
ам. доллар	америк доллар
АХБ	Азийн хөгжлийн банк
БНХАУ	Бүгд Найрамдах Хятад Ард Улс
ДНБ	Дотоодын нийт бүтээгдэхүүн
МЭЗШСТ	Монголын эдийн засгийн шинжилгээ, судалгааны төв
ННФ	Нээлттэй Нийгэм Форум
ОУВС	Олон улсын валютын сан
ТББ	Төрийн бус байгууллага
ТХН	Төсөл хэрэгжүүлэх нэгж
УИХ	Улсын Их Хурал
ҮАГ	Үндэсний аудитын газар
ХАА	Хөдөө аж ахуй
ЯОУХАА	Японы олон улсын хамтын ажиллагааны агентлаг

ӨМНӨХ ҮГ

Монгол Улс гадаад өрийн хэмжээг зохих түвшинд байлгахад анхаарах шаардлага нэн тулгамдаж байна. Манай улс уул уурхайгаас ихээхэн хамааралтай, дотоодын үйлдвэрлэл сул хөгжсөн, харьцангуй жижиг эдийн засагтайн улмаас хэрэглээнийхээ дийлэнх хэсгийг импортоор хангадаг билээ. Импортоос ихээхэн хамааралтай эдийн засгийн хувьд гадаад өрийг дотоодын нийт бүтээгдэхүүнд харьцуулсан хувь хэмжээг томоохон эдийн засагтай орнуудын түвшнээс доогуур байлгахыг олон улсын байгууллагууд, судлаачдын зүгээс зөвлөдөг. Улсын нийт гадаад өр 2022 оны эхний хагас жилийн байдлаар 33.3 тэрбум ам. доллар буюу ДНБ-ий 238 хувьтай тэнцэж байна. Үүнээс 8 тэрбум гаруй ам. доллар нь Засгийн газрын өр бөгөөд Засгийн газрын зүгээс төлөх гадаад өрийн эргэн төлөлтөд хүндрэл учирч, улмаар өрийг дахин санхүүжүүлэх байдал сүүлийн жилүүдэд ажиглагдаж байна.

Өнөөгийн байдлаар орлого багатай олон орон өрийн хямралтай тулаад байна. Тухайлбал, 2022 онд Шри Ланка улс гадаад өрийн төлбөр дээрээ дефолт зарласан бол Аргентин улсын хувьд дефолтын эрсдэл үүссэн, Пакистан улс мөн санхүүгийн хүндрэлтэй тулжээ. Монгол Улсын Засгийн газрын гадаад зээлийн үлдэгдэл 5.8 тэрбум ам. доллартой, гадаад үнэт цаасны үлдэгдэл 2.7 тэрбум ам. доллартой тус тус тэнцэж байна. Засгийн газар гадаад зээлийг олон тооны төсөл, хөтөлбөрт зарцуулж байна. Эдгээр зээлийн эргэн төлөлт улсын төсвөөс хийгдэх тул төслүүдийн үр ашиг, зарцуулалтын мэдээллийн нээлттэй байдлыг хангаж олон нийт хяналт тавих боломж олгох нь чухал болж байна. Иймд Засгийн газрын гадаад зээлийн мэдээлэл, төслүүдийн санхүүгийн ил тод байдлын судалгааг “Монголын эдийн засгийн шинжилгээ, судалгааны төв” ТББ-ын С.Баттулгаар ахлуулсан баг хийж гүйцэтгэлээ.

Судлаачдын зүгээс Засгийн газрын гадаад зээлийн 2000-2021 оны өгөгдөлд дүн шинжилгээ хийснээс гадна гадаад зээлийн санхүүжилттэй төслүүдийн санхүүгийн ил тод байдалд Шилэн дансны мэдээлэл болон Сангийн яамнаас хөгжүүлсэн “Засгийн газрын гадаад зээл, тусламжийн удирдлагын мэдээллийн систем” дэх мэдээлэлд үндэслэн дүгнэлт хийжээ. Судалгаанаас үзэхэд Засгийн газрын урт хугацаат зээл ихээхэн өссөн ба 2018-2020 онд гадаад зээлийн 44.1 хувийг төсвийн дэмжлэг, 16.5 хувийг зам, тээвэр, 7.2 хувийг эрчим хүч, 5.3 хувийг

усан хангамж, хотын дэд бүтэц, 4.6 хувийг эрүүл мэнд, 2.5 хувийг боловсролын салбарт тус тус зарцуулсан байна.

Гадаадын зээл, тусламжийн хөрөнгөөр санхүүжин хэрэгжиж буй төсөл, арга хэмжээний хэрэгжилтийн мэдээллийн ил тод байдал хангалтгүй байгаа нь судалгаанаас харагдлаа. Тухайлбал, судалгаанд гадаадын зээл, тусламжийн 109 төсөл, арга хэмжээг хамруулснаас 2018-2021 онд Шилэн дансны тухай хуульд заасан мэдээллийн дунджаар 60 гаруй хувийг Шилэн дансны системд нийтэлсэн байна. Гадаадын зээл, тусламжийн хөрөнгөөр хэрэгжиж буй төсөл, арга хэмжээний удирдлагын мэдээллийн системийн мэдээллээс үзэхэд төсөл, арга хэмжээний хүрээнд хийгдэж буй ажлууд нь хийгдээд дууссан эсэх, ямар төсөв хөрөнгө зарцуулагдсан, хэр чанартай гүйцэтгэсэн зэргийг нэгтгэсэн мэдээллийг олон нийтэд ойлгомжтой байдлаар тайлагнахгүй байна.

Судалгааг амжилттай хийж гүйцэтгэн Засгийн газрын гадаад зээлийн мэдээлэл, төслүүдийн санхүүгийн ил тод байдлыг сайжруулахтай холбоотой санал, зөвлөмж боловсруулсан С.Баттулгаар ахлуулсан судалгааны баг, судалгааны тайланг сайжруулахад үнэтэй санал, шүүмж өгч ажилласан хөндлөнгийн шинжээч Н.Дорждарь, Нээлттэй Нийгэм Форумын Засаглалын хөтөлбөрийн менежер Д.Оюунбадам нарт талархал илэрхийлье. Гадаадын зээл, тусламжийн ашиглалт, төслүүдийн мэдээллийн нээлттэй байдлын талаар олон нийтийн дунд хэлэлцүүлэг өрнүүлэхэд энэхүү судалгаа чухал хувь нэмэр оруулна хэмээн найдаж байна.

Нээлттэй Нийгэм Форумын Гүйцэтгэх захирал
П.Эрдэнэжаргал

ХУРААНГУЙ

“Монгол Улсын Засгийн газрын гадаад зээлийн мэдээлэл, төслүүдийн санхүүгийн ил тод байдал” сэдэвт энэхүү судалгааг Монголын эдийн засгийн шинжилгээ, судалгааны төв (МЭЗШСТ) төрийн бус байгууллагын судлаачид Нээлттэй Нийгэм Форум (ННФ)-ын захиалгаар гүйцэтгэлээ. Уг судалгааны зорилго Засгийн газрын гадаад зээлийн мэдээлэл, төслүүдийн санхүүгийн ил тод байдал ямар байгааг илрүүлж, түүнийг сайжруулах арга замыг олон улсын туршлагад үндэслэн санал болгоход оршино.

Судалгааны ажлаар Засгийн газрын гадаад зээлийн мэдээллийн 2000-2021 оны өгөгдлийг цуглуулж, бүтцийн шинжилгээ хийн Засгийн газрын богино болон урт хугацаат өрийн бүтэц, гадаад зээлийн хэмжээнд гарсан өөрчлөлт, түүний учир шалтгаан зэргийг тайлбарлахыг зорьсон. Засгийн газрын гадаад зээлийн ашиглалт, аль салбарт ямар төсөл, арга хэмжээ хэрэгжиж байгаа, санхүүжилтийн дүн зэрэг мэдээллийг цуглуулж төслүүдийн үр дүнтэй байдалд дүгнэлт хийхийг оролдлоо. Улмаар дээрх төслүүдийн санхүүгийн ил тод байдлыг төсөв/гүйцэтгэл, хөрөнгө оруулалт, тендер, худалдан авалт болон бусад мэдээлэл агуулсан шилэн дансны мэдээлэл, гадаад улс, олон улсын байгууллагын зээл, тусламжийн хөрөнгөөр хэрэгжиж буй төсөл, арга хэмжээнд үр дүнд суурилсан хяналт, шалгалт-үнэлгээ хийх зорилго бүхий Удирдлагын мэдээллийн систем (<https://odamis.mof.gov.mn/>)-ийн мэдээлэлд үндэслэн шинжилсэн. Судалгааны ажлын төгсгөлд бусад орнуудын Засгийн газрын гадаад зээлийн мэдээлэл болон төслүүдийн санхүүгийн ил тод байдлыг хэрхэн хангадаг тухай сайн туршлагыг Гүрж, Өмнөд Африк, Бразил, Мексик зэрэг төсвийн нээлттэй байдлын индексээр тэргүүлэгч улсуудын жишгээр судаллаа.

Дүн шинжилгээнээс үзэхэд сүүлийн жилүүдэд Засгийн газрын гадаад өр Монгол Улсын нийт гадаад өрийн $\frac{1}{4}$ орчим хэсгийг эзэлж байна. 2021 оны эцсийн байдлаар Засгийн газрын урт хугацаат өрийн бичгийн үлдэгдэл 2.7 тэрбум доллар байгаа бол урт хугацаат зээлийн үлдэгдэл 5.8 тэрбум доллар байна. Урт хугацаат зээл 2011 он буюу 10 жилийн өмнөхтэй харьцуулахад даруй 3 дахин өсжээ. 2018-2020 оны дэлгэрэнгүй мэдээлэлд үндэслэн шинжлэхэд гадаад зээлийн 44.1 хувийг төсвийн дэмжлэг, 16.5 хувийг зам, тээвэр, 7.2 хувийг эрчим хүч, 5.3 хувийг усан хангамж, хотын дэд бүтэц, 4.6 хувийг эрүүл мэнд, 2.5 хувийг боловсролын салбарт тус тус зарцуулжээ. Гадаад зээлийн хөрөнгийн үндсэндээ

тал орчмыг нь нийгмийн халамжийн зарлагын өсөлтөөр нөхцөлдсөн сангийн тэлэх бодлогоос үүдэлтэй нэгдсэн төсвийн тэнцлийн алдагдлыг нөхөхөд зарцуулж байгаа нь эдийн засгийн бодит салбарыг дэмжсэн төсөл, арга хэмжээг санхүүжүүлэх эх үүсвэрийг бууруулахад хүргэж байна. Монгол Улсын 2018-2021 оны хөрөнгө оруулалтын хөтөлбөрийн нийт санхүүжилтийн дүнгийн 23.7 хувийг 2018 онд, 14.8 хувийг 2019 онд, 20.4 хувийг 2020 онд тус тус гадаад зээл, тусламжаар санхүүжүүлэхээр төлөвлөж, гүйцэтгэлээр 2018 онд 87.6, 2019 онд 30.4, 2020 онд 55.2 хувийг тус тус санхүүжүүлсэн нь гадаад зээлийн хөрөнгө улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд их хэмжээгээр ашиглагддаг гэдгийг харуулж байгаа юм.

Энэхүү судалгаанд гадаад улс, олон улсын байгууллагын зээл, тусламжийн хөрөнгөөр санхүүжин хэрэгжиж буй 109 төсөл, арга хэмжээг хамруулснаас 2018-2021 онд Шилэн дансны тухай хуульд заасан мэдээллийн дунджаар 60 гаруй хувийг Шилэн дансны системд ил тод, нээлттэй байршуулсан байна. Төсөл хэрэгжүүлэх нэгж (ТХН)-үүдийн шилэн дансны 2021 оны мэдээллийг шалгахад “Санхүүгийн тайланд хийсэн аудитын дүгнэлт”-ийг 51 хувь нь огт байршуулаагүй байна. “Өмнөх оны төсвийн зарлагын хэмнэлт, туслах үйл ажиллагааны орлогоос давсан хэсгийг урамшуулалд зарцуулсан тайлан” гэсэн мэдээллийг 109 төсөл, хөтөлбөрийн 61 хувь нь бүрэн бус оруулсан. “Хөрөнгийн болон урсгал зардалд тусгагдсан арга хэмжээний тендерийн ерөнхий мэдээлэл”-ийг 42 хувь нь бүрэн бус байршуулсан бол “Худалдан авах ажиллагааны тайлан”-г 41 хувь нь огт байршуулаагүй байна. “Тухайн байгууллагын хууль тогтоомжийн дагуу төвлөрүүлэх төлбөр, хураамж, зохицуулалтын үйлчилгээний хөлсний хэмжээнд орсон өөрчлөлт” гэсэн мэдээллийг дөнгөж 3 хувь нь бүрэн байршуулсан бол 66 хувь нь бүрэн бус мэдээлэл оруулжээ.

Гадаад улс, олон улсын байгууллагын зээл, тусламжийн хөрөнгөөр хэрэгжиж буй төсөл, арга хэмжээнд үр дүнд суурилсан хяналт, шалгалт-үнэлгээ хийх зорилго бүхий Удирдлагын мэдээллийн системийн мэдээллээс үзэхэд төсөл, арга хэмжээний талаар дэлгэрэнгүй мэдээлэл хангалттай байгаа мэт боловч үнэн хэрэгтээ төсөл, арга хэмжээний хүрээнд хийгдэж буй ажлууд нь одоо хийгдээд дууссан эсэх, ямар төсөв хөрөнгө зарцуулагдсан, хэр чанартай гүйцэтгэсэн зэргийг нэгтгэсэн мэдээллийг олон нийтэд ойлгомжтой байдлаар тайлагнадаггүй хэвээр байна. Олон нийт дээрх бүх мэдээллийг нэг бүрчлэн үзэж хооронд нь харьцуулах, англи хэлээр байгаа төслийн баримт бичгийг орчуулж уншихгүй нь түгээмэл тул гэрээний үнийн дүнгийн хэдэн хувь нь зарцуулагдсаны үр дүнд төсөл, арга хэмжээний ажлын аль хэсэг нь хийгдсэн тухай мэдэх боломжгүй юм. “Олон улсын төсвийн түншлэл”-ийн Төсвийн нээлттэй байдлын

судалгааны 2021 оны дүнгээр төсвийн ил тод байдлаар тэргүүлэгч орнуудын туршлагаас үзэхэд гадаад зээлийн санхүүжилтийн мэдээллийг улирал болон жилийн давтамжтайгаар хүснэгт болгон татаж аваад нэмэлт боловсруулалт хийх боломжтой нээлттэй өгөгдөл хэлбэрээр, төдий л олон мэдээллийн нэгжгүйгээр түгээж байна.

Судалгаанаас гарсан дээрх үр дүнгүүдэд үндэслэн Засгийн газрын гадаад зээлийн мэдээлэл, төслүүдийн санхүүгийн ил тод байдлыг сайжруулахтай холбоотой дараах санал, зөвлөмжийг судлаачдын зүгээс боловсруулав.

Үүнд:

Мэдээллийн агуулга, ил тод байдлыг сайжруулах чиглэлээр:

- Засгийн газрын гадаад зээл, түслэмжийн төсөл, арга хэмжээний мэдээллийн нэгдсэн санд төсвийн мэдээллийг тухайн санхүүжилтийг зарцуулан хийж буй ажлын гүйцэтгэлтэй нь холбож мэдээлэх, ажлын явцын талаар үнэн, бодитой, цаг үеийн мэдээлэл бүрэн оруулах;
- Шилэн дансны тухай хууль болон журмын хэрэгжилтийг түүштай хангуулж, шилэн дансны системд мэдээлэл оруулагч болон иргэдийн мэдээлэл ашиглалтыг сайжруулах арга хэмжээг төлөвлөж хэрэгжүүлэх (өгөгдлийн тэмцээн, судалгааны ажлын уралдаан зарлах гэх мэт).

Мэдээллийн хэлбэрийг сайжруулах чиглэлээр:

- Төсөв, санхүүгийн болон төсөл, арга хэмжээний ил тод байдлын системүүд дээр байршуулж буй мэдээллийг олон нийтэд зориулж аль болох боловсруулалттай, энгийн, ойлгомжтой хэлбэрээр (инфографик, хөдөлгөөнт дүрслэл, газрын зураг дээрээс харах гэх мэт) иж бүрэн, нээлттэй өгөгдлийн стандартын дагуу тайлагнах;
- Засгийн газрын гадаад зээл болон гадаад зээлийн хөрөнгөөр хэрэгжиж буй төслүүдийн хэрэгжилтийн үр дүн, зарцуулсан санхүүжилтийн мэдээллийг Сангийн яам, эсвэл Эдийн засаг, хөгжлийн яам жил бүр товхимол гарган олон нийтэд түгээж (цаасаар байх албагүй) ил тод байдлыг хангаж хэвших.

Гадаад зээлийн хөрөнгийн ашиглалтыг сайжруулах чиглэлээр:

- Гадаад зээлийн хөрөнгийг нэгдсэн төсвийн тэнцлийн алдагдлыг нөхөхөд зарцуулж, эдийн засгийн бодит салбарыг дэмжих төсөл, арга хэмжээг санхүүжүүлэх боломжтой байсан эх үүсвэрийг хомсдолд оруулж байгаа

ужгирсан буруу зуршлыг төсвийн сахилга батыг сайжруулж, алдагдлыг бууруулах замаар зогсоох;

- Улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөрт тусгагдаагүй, Өрийн удирдлагын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.5.4, 18.5.7-д заасан шаардлагыг хангаагүй төсөл, арга хэмжээг гадаад зээлийн хөрөнгөөр санхүүжүүлж байгааг нэн даруй зогсоох.

1 | Удиртгал

“Монгол Улсын Засгийн газрын гадаад зээлийн мэдээлэл, төслүүдийн санхүүгийн ил тод байдал” сэдэвт энэхүү судалгааг Монголын эдийн засгийн шинжилгээ, судалгааны төв” төрийн бус байгууллагын судлаачид Нээлттэй нийгэм форум (ННФ)-ын захиалгаар гүйцэтгэлээ.

Уг судалгааны зорилго Засгийн газрын гадаад зээлийн мэдээлэл, төслүүдийн санхүүгийн ил тод байдал ямар байгааг тодруулж, түүнийг сайжруулах арга замыг олон улсын туршлагад үндэслэн санал болгоход оршино.

Дээрх зорилгод хүрэхийн тулд судалгааны баг тайлангийн хоёрдугаар бүлэгт Засгийн газрын гадаад зээлийн мэдээллийн 2000-2021 оны өгөгдлийг цуглуулж, бүтцийн шинжилгээ хийн, Засгийн газрын богино хугацаат болон урт хугацаат өрийн бүтэц, гадаад зээлийн хэмжээнд гарсан өөрчлөлт, түүний учир шалтгаан зэргийг тайлбарлахыг зорьсон. Тайлангийн гуравдугаар бүлэгт Засгийн газрын гадаад зээлийн ашиглалт, аль салбарт ямар төсөл, арга хэмжээ хэрэгжиж байгаа, санхүүжилтийн дүн зэрэг мэдээлэл цуглуулж, төслүүдийн үр дүнтэй байдалд дүгнэлт хийхийг оролдлоо. Улмаар дөрөвдүгээр бүлэгт дээрх төслүүдийн санхүүгийн ил тод байдлыг төсөв/гүйцэтгэл, хөрөнгө оруулалт, тендер, худалдан авалт болон бусад гэсэн мэдээлэл агуулсан шилэн дансны мэдээлэл, гадаад улс, олон улсын байгууллагын зээл, тусламжийн хөрөнгөөр хэрэгжиж буй төсөл, арга хэмжээнд үр дүнд суурилсан хяналт, шалгалт-үнэлгээ хийх зорилго бүхий Сангийн яамны удирдлага, мэдээллийн систем (odamis.mof.gov.mn)-ийн мэдээлэлд үндэслэн шинжилсэн. Судалгааны ажлын тавдугаар бүлэгт бусад орнуудын Засгийн газрын гадаад зээлийн мэдээлэл болон төслүүдийн санхүүгийн ил тод байдлыг хэрхэн хангадаг тухай сайн туршлагыг Гүрж, Өмнөд Африк, Бразил, Мексик зэрэг төсвийн нээлттэй байдлын индексээр тэргүүлэгч улсуудын жишгээр судаллаа. Эцэст нь тайлангийн зургаадугаар бүлэгт нэгдсэн дүгнэлт оруулж, долоодугаар бүлэгт манай улс Засгийн газрын гадаад зээлийн мэдээлэл, төслүүдийн санхүүгийн ил тод байдлыг хангах талаар ямар арга хэмжээг хэрэгжүүлбэл зохих тухай санал, зөвлөмж боловсруулсан.

Судалгааны арга зүйн хувьд бид Монголбанк, Сангийн яам, Үндэсний аудитын газар зэрэг төрийн байгууллагуудын эх үүсвэрээс тоон мэдээлэл, баримт цуглуулж, тоон аргаар боловсруулан шинжилж, өөрсдийн дүгнэлтийг хийв.

Түүнчлэн төсөв, санхүү, худалдан авалтын мэдээллийг төвлөрүүлсэн шилэн дансны систем, төсөл, арга хэмжээний үр дүн, гүйцэтгэлийн мэдээлэл бүхий удирдлага, мэдээллийн систем зэргийн мэдээлэлд шинжилгээ хийлээ. Тухайлбал, энэхүү судалгааны ажлын хүрээнд 109 төсөл, хөтөлбөрийн шилэн данс дахь 2021 оны мэдээллийг төсөл, хөтөлбөр нэг бүрээр шалгасан. Олон улсын туршлагыг судлахдаа тухайн орны Сангийн яам, Засгийн газраас ажиллуулдаг нээлттэй мэдээллийн цахим хуудсыг ашиглав.

Тус судалгааны ажлыг гүйцэтгэх боломж олгосон ННФ-ын хамт олон, тэр дундаа үнэтэй санал, зөвлөмж өгч хамтран ажилласан ННФ-ын Засаглалын хөтөлбөрийн менежер Д.Оюунбадамд судалгааны багийн зүгээс талархал илэрхийлж байна.

2 | Засгийн газрын гадаад зээл, түүний бүтэц (2000-2021 он)

Сүүлийн жилүүдэд Засгийн газрын гадаад өрийн үлдэгдэл Монгол Улсын нийт гадаад өрийн үлдэгдлийн ¼ орчим хэсгийг эзэлж байна. Хүснэгт 1-д Монгол Улсын нийт гадаад өр, Засгийн газрын гадаад өрийн үлдэгдлийг 2000-2021 оноор харууллаа. Нийт гадаад өр нь Засгийн газрын өрнөөс гадна Төв банк, Төв банкнаас бусад хадгаламжийн байгууллага, бусад салбарын гадаад өр, шууд хөрөнгө оруулалт: компани хоорондын зээллэг зэргээс бүрддэг. Засгийн газрын гадаад өр нь богино хугацаат болон урт хугацаат гадаад өрийн нийлбэр юм. Богино хугацаат өр нь харилцах, хадгаламж; өрийн бичиг; зээл; худалдааны зээл болон урьдчилгаа; бусад өглөг гэсэн бүтэцтэй бол урт хугацаат өр нь зээлжих тусгай эрхийн хуваарилалт; харилцах, хадгаламж; өрийн бичиг; зээл; худалдааны зээл болон урьдчилгаа гэсэн бүрэлдэхүүнтэй байдаг.

Манай улсын Засгийн газрын гадаад өр нь зөвхөн урт хугацаат өрийн бичиг, урт хугацаат зээлээс бүрджээ. Дэлхийн санхүү, эдийн засгийн хямралтай байсан 2009 онд уг үзүүлэлтийн хувь хамгийн их буюу 32.3 байсан нь тухайн үед Засгийн газар эдийн засгийн хүндрэлийг даван туулахын тулд урт хугацаат өрийн бичиг гаргаж, урт хугацаат зээл нэмж авсантай холбоотой байсан.

Хүснэгт 1. Монгол Улсын нийт гадаад өр, Засгийн газрын гадаад өрийн үлдэгдэл
(сая ам. доллар)

Он	Нийт гадаад өр	Засгийн газрын гадаад өр		Засгийн газрын урт хугацаат өрийн бичиг		Засгийн газрын урт хугацаат зээл	
		Хэмжээ	Нийт гадаад өрөнд эзлэх хувь	Хэмжээ	Нийт гадаад өрөнд эзлэх хувь	Хэмжээ	Нийт гадаад өрөнд эзлэх хувь
2000	4,214.7	838.3	19.9%	0.0	0.0%	838.3	19.9%
2001	4,244.4	852.2	20.1%	0.0	0.0%	852.2	20.1%
2002	4,398.7	984.9	22.4%	0.0	0.0%	984.9	22.4%
2003	4,737.7	1,290.3	27.2%	50.0	1.1%	1,240.3	26.2%
2004	4,730.4	1,360.0	28.8%	0.0	0.0%	1,360.0	28.8%
2005	4,577.5	1,311.8	28.7%	0.0	0.0%	1,311.8	28.7%
2006	4,702.3	1,413.9	30.1%	0.0	0.0%	1,413.9	30.1%
2007	4,995.6	1,528.8	30.6%	0.0	0.0%	1,528.8	30.6%


Хүснэгт 1. Үргэлжлэл

2008	5,250.4	1,602.2	30.5%	0.0	0.0%	1,602.2	30.5%
2009	5,822.6	1,879.6	32.3%	70.6	1.2%	1,809.0	31.1%
2010	7,127.8	1,882.2	26.4%	113.6	1.6%	1,768.6	24.8%
2011	10,908.3	2,043.3	18.7%	126.6	1.2%	1,916.8	17.6%
2012	17,210.5	3,599.3	20.9%	1,586.9	9.2%	2,012.5	11.7%
2013	19,829.7	3,534.6	17.8%	1,415.4	7.1%	2,119.2	10.7%
2014	21,850.5	3,500.8	16.0%	1,402.8	6.4%	2,098.0	9.6%
2015	22,717.8	3,759.9	16.6%	1,472.5	6.5%	2,287.3	10.1%
2016	24,624.5	4,868.6	19.8%	2,063.5	8.4%	2,805.1	11.4%
2017	27,492.7	7,321.0	26.6%	3,548.5	12.9%	3,772.4	13.7%
2018	28,714.9	7,184.2	25.0%	2,946.0	10.3%	4,238.2	14.8%
2019	30,702.3	7,806.2	25.4%	3,123.3	10.2%	4,682.9	15.3%
2020	32,361.8	8,653.8	26.7%	2,862.2	8.8%	5,791.7	17.9%
2021	33,805.5	8,454.2	25.0%	2,655.7	7.9%	5,798.5	17.2%

Эх сурвалж: Монголбанк

Засгийн газар 2009 оноос урт хугацаат өрийн бичиг тогтмол гаргаж эхэлсэн ч Засгийн газрын гадаад өрөнд түүний эзлэх хувь нэг оронтой тоонд багтаж байв. Харин 2012 оноос (Чингис бонд гаргаснаас эхлэн) урт хугацаат өрийн бичгийн Засгийн газрын гадаад өрөнд эзлэх хувь 44.1 болж огцом өссөн бөгөөд сүүлийн хоёр жилд л 31.4-33.1 хувь болж бага зэрэг буурчээ. 2021 оны эцсийн байдлаар Засгийн газрын урт хугацаат өрийн бичгийн үлдэгдэл 2.7 тэрбум доллар байгаа бол урт хугацаат зээлийн үлдэгдэл 5.8 тэрбум доллар байна. Урт хугацаат зээл 2011 он буюу 10 жилийн өмнөхтэй харьцуулахад даруй 3 дахин өссөн.

График 1. Засгийн газрын гадаад өрийн үлдэгдэл, 2011-2021 он (тэрбум ам. доллар)



Эх сурвалж: Монголбанк

Засгийн газрын урт хугацаат зээл 2016 оноос эхлэн жил бүр 500 сая ам. доллар орчмоор нэмэгдэж байсан ч 2020 он буюу сонгуулийн жил 1.1 тэрбум доллароор огцом нэмэгджээ. Харин урт хугацаат өрийн бичиг 2012, 2017 (Хуралдай, Гэрэгэ бонд) оныг эс тооцвол харьцангуй бага өсөлттэй байсан. Цаашилбал 2018 онд 602.5 сая доллароор бүүрчээ. Тиймээс Засгийн газар урт хугацаат гадаад зээлээр ямар ажил хийж, ямар үр дүнд хүрснийг тодруулах зайлшгүй шаардлагатай. Хамгийн чухал нь уг хөрөнгөөр хэрэгжиж буй төслүүдийн санхүүгийн ил тод байдал, санхүүжилтийн мэдээллийг хийсэн ажлын гүйцэтгэлтэй нь холбон тайлагнаж байгаа эсэх зэргийг тодруулах хэрэгцээ байна.

2021 оны эцсийн байдлаар Монгол Улсын нийт гадаад өрийн үлдэгдлийг улсаар буюу эх сурвалжаар нь ангилж үзэхэд олон зээлдэгч оролцсон зээлээс гадна Нидерланд, БНХАУ тэргүүлж байна (Хүснэгт 2). Энэ нь гадаад өрийн хувьд нэг улсаас өндөр хамааралтай болох эрсдэлтэй холбогдох тул анхаарах хэрэгтэй юм.

Хүснэгт 2. Монгол Улсын нийт гадаад өрийн үлдэгдэл, улсаар (дүнд эзлэх хувь)

№	Зээлдэгч	Дүнд эзлэх хувь
1	Олон зээлдэгч оролцсон	42.2
2	Нидерланд	24.9
3	БНХАУ	11.2
4	Япон	5.3
5	Хонконг	3.8
6	Сингапур	3.7

Эх сурвалж: Монголбанк


3

Засгийн газрын гадаад зээлээр хэрэгжиж буй төслүүд, тэдгээрийн үр дүнтэй байдал

Монгол Улс Өрийн удирдлагын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.1-д “Төсвийн алдагдлыг санхүүжүүлэх”, 12.1.5-д “Улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөрийг санхүүжүүлэх” гэж заасан заалтуудыг тус тус үндэслэн хандивлагч орон, олон улсын байгууллагаас гадаад зээл авч байна.

Үндэсний аудитын газар (ҮАГ)-ын 2021 оны гүйцэтгэлийн аудитын тайланд дурдсанаар манай улс 1991-2020 онд хандивлагч орон, олон улсын байгууллагатай 267 зээлийн гэрээ байгуулж, нийт 6,887.9 сая ам. доллар буюу 19,706.1 тэрбум төгрөгийн гадаад зээл авч ашиглажээ. Нийт гадаад зээлийн 27.3 хувь буюу 1,883.8 сая ам. доллартой тэнцэх 5,389.4 тэрбум төгрөгийн 302 гэрээг байгуулж, дотоодод дамжуулан зээлдүүлсэн байна. Тус хугацаанд авсан нийт зээлийн 35.7 хувийг АХБ-наас, 20.3 хувийг БНХАУ-аас, 15.3 хувийг ЯОУХАА-аас, 8.8 хувийг Дэлхийн банкнаас, 19.9 хувийг бусад хандивлагч орон, олон улсын байгууллагаас тус тус авч ашиглажээ.


График 2. Засгийн газрын авсан гадаад зээл (сая ам. доллар)



Эх сурвалж: ҮАГ

2018-2020 оны дэлгэрэнгүй мэдээлэлд үндэслэн шинжлэхэд манай улсын Засгийн газар хандивлагч орон, олон улсын байгууллагаас 2018 онд 590.7 сая ам. доллар, 2019 онд 610.2 сая ам. доллар, 2020 онд 1,195.0 сая ам. доллар, нийт 2,395.9 сая ам. долларын гадаад зээл авч ашигласан.

График 3. Засгийн газрын гадаад зээлийн ашиглалт, салбараар, 2018-2020 он




Эх үүсвэр: УАГ

Эдгээр гадаад зээлийн 44.1 хувийг төсвийн дэмжлэг, 16.5 хувийг зам, тээвэр, 7.2 хувийг эрчим хүч, 5.3 хувийг усан хангамж, хотын дэд бүтэц, 4.6 хувийг эрүүл мэнд, 2.5 хувийг боловсролын салбарт тус тус зарцуулжээ.

Сангийн яамны 2019 оны мэдээлэлд тулгуурлан дэлгэрүүлэхэд тухайн төсвийн жилд нийт 111 зээлийн төсөл, 41 тусламжийн төслийг “байгаль орчныг хамгаалах, агаарын бохирдлыг бууруулах, бохир ус цэвэрлэх байгууламжийг шинэчлэх, аялал жуулчлалыг дэмжих”, “сургууль, цэцэрлэг, эмнэлгийн үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх, чанарыг сайжруулах”, “нефть бүтээгдэхүүн, эрчим хүчний хангамжийн найдвартай байдлыг нэмэгдүүлэх, дэд бүтцийн бүтээн байгуулалт хийх”, “нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг дэмжих, худалдаа, бизнесийн орчныг сайжруулах” болон бусад чиглэлээр санхүүжүүлэхээр төлөвлөж байжээ. Тодруулбал:

- Нефть бүтээгдэхүүн, эрчим хүчний хангамжийн найдвартай байдлыг нэмэгдүүлэх, дэд бүтцийн бүтээн байгуулалт хийх ажлын хүрээнд нийт гадаад зээл, тусламжийн 39 хувийг;
- Байгаль орчныг хамгаалах, агаарын бохирдлыг бууруулах, бохир ус цэвэрлэх байгууламжуудыг шинэчлэх, аялал жуулчлалыг дэмжих чиглэлээр нийт гадаад зээл, тусламжийн 21 хувийг;
- Сургууль, цэцэрлэг, эмнэлгийн үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх, чанарыг сайжруулах чиглэлээр нийт гадаад зээл, тусламжийн 17 хувийг;
- Нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг дэмжих, худалдаа, бизнесийн орчныг сайжруулах хүрээнд нийт гадаад зээл, тусламжийн 15 хувийг;
- Бусад чиглэлийн төслийн хүрээнд¹ нийт гадаад зээл, тусламжийн 8 хувийг тус тус зарцуулахаар төлөвлөсөн байв.

График 4. Монгол Улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөрийн нийт санхүүжилтийн дүнд гадаадын зээл, тусламжийн эзлэх хувь



Эх сурвалж: УАГ

Монгол Улсын 2018-2021 оны хөрөнгө оруулалтын хөтөлбөрийн нийт санхүүжилтийн дүнгийн 2018 онд 23.7, 2019 онд 14.8, 2020 онд 20.4 хувийг тус тус гадаад зээл, тусламжаар санхүүжүүлэхээр төлөвлөж, гүйцэтгэлээр 2018 онд 87.6, 2019 онд 30.4, 2020 онд 55.2 хувийг тус тус санхүүжүүлсэн нь гадаад

¹ Хөдөлмөр, хүн амын хөгжил, нийгмийн хамгаалал; гамшгаас хамгаалах чиглэлийн төслүүд.

зээлийн хөрөнгө улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд их хэмжээгээр ашиглагддаг гэдгийг харуулж байна. Тиймээс гадаад зээлийг хэр үр дүнтэй ашиглаж байгааг улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөрийн хэрэгжилтийн үр дүнтэй байдлаас тодорхой хэмжээгээр харж болно гэсэн үг. Гэтэл улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөрт тухайн газрын сургуулийн насны хүүхдийн тооноос давсан хүчин чадалтай сургуулийн барилга, хөшөө дурсгал барихаар тусгагдаж байгаа талаар шүүмжлэл олонтоо өрнөдөг. Өөрөөр хэлбэл, гадаад зээлийн хөрөнгөөр улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөрийн эдийн засгийн үр өгөөж муутай төсөл, арга хэмжээг санхүүжүүлж, хожим нь хүүгийн хамт төлөх нь зөв жишиг биш юм.

ҮАГ-ын 2021 оны гүйцэтгэлийн аудитын тайланд дурдсанаар улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөрт тусгагдаагүй, Өрийн удирдлагын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.5.4², 18.5.7³-д заасан шаардлагыг хангаагүй буюу зураг төсөв, техник, эдийн засгийн үндэслэлийг хийж баталгаажуулаагүй, нийгмийн болон байгаль орчны нөлөөллийн шинжилгээ хийгдэж баталгаажуулаагүй төсөл, арга хэмжээг гадаад зээлийн хөрөнгөөр санхүүжүүлж байгаа ноцтой зөрчил амь бөхтэй оршин байгаа нь төсөл, арга хэмжээний хэрэгжилт удааширч, төлөвлөсөн үр дүндээ хүрэхгүй байх, эдийн засаг, санхүүгийн үр ашиг нь муудах шалтгаан болж байна гэжээ. Илүү ноцтой нь өнөөдрийг хүртэл УИХ-аас гадаад зээлийн бодлогыг батлаагүй нь гадаад зээлийн хөрөнгийг урт, дунд хугацааны хөгжлийн бодлого, төлөвлөлттэй уялдуулан зарцуулах бодлогын орчин бүрдээгүй байгааг харуулж байна.

Тус тайланд дурдсанаар 2018-2020 онд хэрэгжиж дууссан төсөл, арга хэмжээний 88.9 хувь нь төсөл хэрэгжиж дууссаны дараа төслийн үр нөлөөний үнэлгээг хараат бус мэргэжлийн байгууллагаар хийлгүүлээгүй, тайланг Сангийн яамны удирдлага, мэдээллийн системд⁴ оруулаагүй байсан нь Сангийн сайдын 2015 оны 196 дугаар тушаалаар баталсан “Засгийн газрын гадаад зээлийн хөрөнгийг ашиглах, эдгээр хөрөнгөөр санхүүжих төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх, зохион байгуулах, санхүүжүүлэх, хяналт тавих, үнэлэх журам”-ын 10.1.26 дахь заалтыг хэрэгжүүлээгүй гэсэн үг юм. Энэ нь Засгийн газрын зүгээс гадаад зээлийн хөрөнгөөр хэрэгжсэн төсөл, арга хэмжээний үр нөлөөг төдий л анхаарч үзэхгүй байгаа буюу гадаад зээлийн ашиглалтын үр дүнтэй байдалд төдий л хариуцлагатай ханддаггүйг харуулж байна.


² тухайн төсөл, арга хэмжээний төрлөөс хамааран зураг төсөв, техник, эдийн засгийн үндэслэлийг хийж, баталгаажуулсан байх;

³ тухайн төсөл, арга хэмжээний төрлөөс хамааран нийгмийн болон байгаль орчны нөлөөллийн шинжилгээ хийгдэж, баталгаажуулсан байх.

⁴ www.odamis.mof.gov.mn систем.

ҮАГ-ын 2021 оны гүйцэтгэлийн аудитын тайланд хөндөгдсөн, анхаарал татаж байгаа өөр нэг асуудал бол дотоодод дамжуулсан зээлийн эргэн төлөлт хангалтгүй байгаа явдал юм. Тодруулбал, дотоодод дамжуулан зээлдүүлсэн зээлийн авлагын тайланд эргэн төлөөгүй зээл 2018-2020 оны дунджаар дотоодод дамжуулсан нийт зээлийн 47 хувийг эзэлж, зээлийн үлдэгдэл 2016 онд 790.9 тэрбум төгрөг байсан бол 2020 онд 77.2 хувиар өсөж, жилийн эцэст нийт 73 зээлийн 1,402 тэрбум төгрөгийн үлдэгдэлтэй болсон. Өөрөөр хэлбэл, гадаад зээлийн хөрөнгөөс дотоодод дамжуулсан зээлийн ашиглалт төдий л үр дүнтэй, үр ашигтай байж чадахгүй байна. Өрийн удирдлагын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.5.5-д зааснаар “гадаад зээллэгийн хөрөнгийг дамжуулан зээлдүүлж байгаа тохиолдолд тухайн төсөл, арга хэмжээ эдийн засгийн үр ашигтай, зээллэгийн хөрөнгийг эргэн төлөх чадвартай нь эрсдэлийн үнэлгээгээр тогтоогдсон байх” ёстой. Гэвч үнэн хэрэгтээ дамжуулсан зээлийн эргэн төлөлт муу байгаа нь хуулийн заалт хэрэгжихгүй байна гэж дүгнэх үндэстэй байгаа юм.

График 5. Төсвийн алдагдлыг санхүүжүүлэх зориулалтаар авсан гадаад зээлийн үлдэгдэл (тэрбум төгрөг)



Эх сурвалж: ҮАГ

Дээрх тайланд дурдсанаар Өрийн удирдлагын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.1-д заасныг үндэслэн төсвийн алдагдлыг санхүүжүүлэх зориулалтаар 2018 онд 474.8 тэрбум, 2019 онд 408.1 тэрбум, 2020 онд 1,978 тэрбум, нийт 2,860.9 тэрбум төгрөгийн гадаад зээлийг хандивлагч орон, олон улсын байгууллагаас авсан нь 2018-2020 онд авсан нийт гадаад зээлийн 44.1 хувийг эзэлсэн юм. Төсвийн алдагдлыг санхүүжүүлэх зориулалтаар авсан гадаад зээлийн үлдэгдэл 2018 онд 2,617.7 тэрбум, 2019 онд 3,088.1 тэрбум, 2020 онд 5,223.5 тэрбум төгрөг болжээ. Ингэж гадаад зээлийн хөрөнгийн үндсэндээ талыг шахам


нийгмийн халамжийн зарлагын өсөлтөөр нөхцөлдсөн сангийн тэлэх бодлогоос үүдэлтэй нэгдсэн төсвийн тэнцлийн алдагдлыг нөхөхөд зарцуулж байгаа нь эдийн засгийн бодит салбарыг дэмжсэн төсөл, арга хэмжээг санхүүжүүлэх эх үүсвэрийг бууруулахад хүргэж байна. Энэ нь гадаад зээлийн хөрөнгийн ашиглалтын үр дүнтэй байдлыг мөн багасгаж байгаа хүчин зүйлсийн нэг мөн.

Гадаад улс, олон улсын байгууллагын зээл, түслэмжийн хөрөнгөөр хэрэгжиж буй төсөл, арга хэмжээнүүдийн хүрэх үр дүнтэй холбоотой дараах мэдээллийг Сангийн яамны удирдлага, мэдээллийн системд оруулах шаардлагатай. Үүнд:

1. Төслийн хүрэх үр дүн;
2. Төслийн зорилго;
3. Төслийн хийх ажил;
4. Төслийн шалгуур үзүүлэлтүүд, хүрсэн түвшин;
5. Төслийн үйл ажиллагааны тайлан.

Шилэн дансны мэдээллийн системд мэдээлэл нь орсон 77 төсөл, арга хэмжээний хувьд дээрх байдлаар үр дүнгийн мэдээллээ оруулсан эсэхийг 2022 оны 8 дугаар сарын байдлаар авч үзэхэд дараах байдалтай байсан.

График 6. Гадаад улс, олон улсын байгууллагын зээл, түслэмжийн хөрөнгөөр хэрэгжиж буй төсөл, арга хэмжээнүүд үр дүнгийн мэдээллээ нийтэлсэн байдал



Эх сурвалж: <https://odamis.mof.gov.mn>

Дээрх мэдээллээс дүгнэхэд төсөл, арга хэмжээнүүд зорилго, хүрэх үр дүн, хийх ажлаа маш сайн мэдээлсэн байгаа ч төлөвлөсөн ажил нь хийгдсэн эсэхийг үнэлэхэд ашиглагдах шалгуур үзүүлэлтийг 32% нь огт мэдээллээгүй байсан бол

2021 оны үйл ажиллагааны тайлангаа 43% нь байршуулаагүй, 72% нь төсөл, арга хэмжээний хэрэгжилтийг хянах шалгуур үзүүлэлтийн хүрсэн түвшнийг огт мэдээллээгүй байсан. Цаашилбал төсөл, арга хэмжээнүүдийн 84% нь шалгуур үзүүлэлтийн явцын гүйцэтгэлийн 2021 оны мэдээллийг ил тод болгоогүй байсан нь төсөл, арга хэмжээний хэрэгжилт ямар үр дүнд хүрсэн буюу зорилго, үр дүндээ хүрсэн эсэх, хийх ажлаа хийсэн эсэхийг тодорхой мэдэх боломжгүй болгож байгааг анхаарах хэрэгтэй.

4

Засгийн газрын гадаад зээлээр хэрэгжиж буй төслүүдийн санхүүгийн ил тод байдал

Сангийн сайдын 2021 оны 1 дүгээр сарын 11-ний өдрийн 4 дүгээр тушаалын хавсралтаар батлагдсан “Засгийн газрын гадаад зээлийн хөрөнгийг ашиглах, эдгээр хөрөнгөөр санхүүжих төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх, зохион байгуулах, санхүүжүүлэх, хяналт тавих, үнэлэх журам”-ын дагуу Засгийн газрын гадаад зээлийн хөрөнгөөр хэрэгжиж буй төслүүд санхүүгийн удирдлагыг хэрэгжүүлдэг бөгөөд холбогдох хууль, журамд заасны дагуу жил бүр санхүүгийн аудит хийлгэдэг байна. Улмаар тайланг ҮАГ-т хүргүүлдэг. Хэдийгээр дээрх тайлангууд www.audit.mn зэрэг цахим хуудсаар олон нийтэд нээлттэй хүрдэг ч олон нийт, иргэдийн хувьд төсөл бүрийн аудитлагдсан тайлантай танилцаж, 20 гаруй хуудсыг нягтлан уншиж судлах боломж тэр бүр байхгүй нь илэрхий тул аудитын тайлангийн үндсэн гол мэдээлэл, илэрсэн алдаа дутагдал, аудитын мөрөөр авч хэрэгжүүлбэл зохих арга хэмжээ зэргийг олон нийтэд ойлгомжтой хэлбэрээр тайлагнах боломж бүрдүүлэх хэрэгтэй байна.

Шилэн дансны цахим системд мэдээлэл нийтэлсэн байдал

Засгийн газрын гадаад зээлийн хөрөнгөөр санхүүжүүлэх төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх чиг үүрэгтэй ТХН-үүд Шилэн дансны системд ерөнхийдөө 20 төрлийн мэдээлэл байршуулж, мэдээллийг ил тод болгодог. ҮАГ-ын 2021 оны гүйцэтгэлийн аудитын тайланд дурдсанаар ТХН-үүд нийтэлбэл зохих мэдээллийн дунджаар 64.2 хувийг 2018 онд, 61.9 хувийг 2019 онд, 61.2 хувийг нь 2020 онд байршуулсан. Өөрөөр хэлбэл, иргэд, олон нийтэд нийт мэдээллийн 62.4 орчим хувь нь ил болсон гэсэн үг. Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.6-д заасан төсвийн хэмнэлт, хэтрэлт, түүний шалтгааны тайлбар гэсэн улирал бүр мэдээлэх үзүүлэлтийг хамгийн бага буюу 37 хувьтай мэдээлсэн байгаа нь олон нийтийн хувьд хамгийн их сонирхдог нэг мэдээллийн ил тод, нээлттэй байдал хангалтгүй гэж үзэхэд хүргэж байна.

Бид энэхүү судалгааны ажлын хүрээнд ТХН-үүдийн шилэн дансны 2021 оны мэдээллийг шалгахад нийтэлбэл зохих мэдээллийн 64 хувийг нь байршуулжээ. ТХН-ээс байршуулдаг шилэн дансны мэдээлэл нь дараах гурван бүлэгт ангилагддаг. Үүнд:

- Цар тахлын улмаас Засгийн газраас төсөл, хөтөлбөрүүдийн цар тахлын үеийн төсвийн орлого, зарцуулалтын мэдээллийн нээлттэй байдлыг хангах зорилгоор “Ковид-19 цар тахалтай холбоотой мөнгөн хандив, тусламжийн орлого, зарцуулалтын мэдээ”, “Ковид-19 цар тахалтай холбоотой материаллаг хандив, тусламжийн орлого, зарцуулалтын мэдээ”-г нэмэлтээр Шилэн дансны төсөв/гүйцэтгэл хэсэгт оруулжээ.

2021 оны байдлаар нийт 113 төсөл, хөтөлбөрөөс 109 төсөл, хөтөлбөр мэдээллээ шилэн дансанд байршуулсан байна. Эдгээр 109 төсөл, хөтөлбөрийн 2,230 мэдээлэл орсноос 1,428 мэдээлэл буюу 64% нь бүтэн болон бүрэн бус байдлаар оржээ. Дэлгэрэнгүйг Хавсралт 1-ээс үзнэ үү.

График 7. Төслүүд төсөв/гүйцэтгэлийн мэдээллээ нийтэлсэн байдал, 2021 он



⁵ Дараа жилийн зорилтот түвшин, цар тахалтай холбоотой 2 мэдээлэл, нийт 3 хүртэлх мэдээлэл нэмэгдсэн.

⁶ Зарим төсөл төсөв/гүйцэтгэл дээр 10 мэдээлэл оруулж байгаа. Тэр тохиолдолд 21, төсөв/гүйцэтгэл дээр 12 мэдээлэл оруулсан тохиолдолд 23 мэдээлэл болж байгаа.

График 7. Үргэлжлэл



Эх сурвалж: www.shilendans.gov.mn

Тайлбар: Оронгийн бүхэлчлэлээс хамааран 100 хувь гарахгүй байх боломжтой.


График 7-гоос харахад Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.6-д заасан “Төсвийн байгууллагын батлагдсан төсөв, гүйцэтгэл, хэмнэлт, хэтрэлтийн шалтгаан тайлбарын хамт” гэсэн мэдээллийг хамгийн өндөр буюу 61 хувьтай байршуулжээ. Харин тус хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.5-д заасан “Санхүүгийн тайланд хийсэн аудитын дүгнэлт”-ийг 51 хувь нь огт байршуулаагүй байна. “Ковид-19 цар тахалтай холбоотой мөнгөн хандив, тусламжийн орлого, зарцуулалтын мэдээ”, “Ковид-19 цар тахалтай холбоотой материаллаг хандив, тусламжийн орлого, зарцуулалтын мэдээ”-г ил тод болгох 19 төсөл, хөтөлбөр⁷ байгаагийн 60 орчим хувь нь мэдээллээ оруулаагүй байв. “Өмнөх оны төсвийн зарлагын хэмнэлт, туслах үйл ажиллагааны орлогоос давсан хэсгийг урамшуулалд зарцуулсан тайлан” гэсэн мэдээллийг 109 төсөл, хөтөлбөрийн 61% нь бүрэн бус оруулсан байна.

Төсөв/гүйцэтгэлийн мэдээллээ сайн нийтэлсэн төслүүдээс дурдвал, Улаанбаатар хотын нийтийн аж ахуйг сайжруулах хоёр дахь төслийн удирдах нэгж; Аймгуудын төвийн хатуу хог хаягдлын менежментийн төсөл; Биологийн олон янз байдлыг хамгаалах, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох төсөл; ЭМСХХ-5: Яаралтай үеийн тусламжийн нэмэлт санхүүжилт төсөл; Эрчим хүчний төсөл-2 зэрэг төслүүд байна. Харин Баянхонгор-Байдрагийн гүүр чиглэлийн 129 км хатуу хүчилттай авто зам барих төсөл; Бичил санхүүгийн хөгжлийн сан; Гэмтэл согог судлалын үндэсний төвийн харьяа Түлэнхийн төвийн барилга

⁷ Зарим төсөл, хөтөлбөрийн хувьд энэ хоёр мэдээллийг оруулах талбар байгаагүй.

барих төсөл; Инновацыг дэмжих төсөл; Иргэдийн оролцоо төсөл зэрэг төслүүд төсөв/гүйцэтгэлийн мэдээллээ ил болгоогүй байв. Дэлгэрэнгүйг Хавсралт 2-оос үзнэ үү.

График 8. Төслүүд хөрөнгө оруулалт, тендер, худалдан авалтын мэдээллээ нийтэлсэн байдал, 2021 он




Эх сурвалж: www.shilendans.gov.mn

